



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА БАЯН- ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Санхүүгийн аудитын тайлан

Төрийн сангийн тогтолцоо, 2017 оны үйл ажиллагааны үр дүн



**ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР
ДҮНГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ
БАЙНА.**

Баян-Өлгий аймаг, Өлгий сум

АГУУЛГА Тайланг бэлтгэсэн: Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар Дарга бөгөөд тэргүүлэх аудитор М.Хуанган Аудитын менежер Х.Женисбек Аудитын баг Ахлах аудитор Д.Назгүл Аудитор Р.Баярмаа 2018 оны 11 дүгээр сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70422954, 70422930, 70423073 дугаарын утсаар хандана уу. Хаяг: Аймгийн ЗДТГазрын байр 1-давхар ХАЯГ: Аймгийн ЗДТГазрын байр, 1 дүгээр давхар 110, 112 тоот өрөө	Товчилсон үгийн тайлбар3 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй4 Бүлэг 1 А.1. Төрийн сангийн эрхзүйн орчин, тогтолцоог оновчтой зохион байгуулах шаардлага байна. А.1.1.Төрийн сангийн чиг үүргийг холбогдох хуульд тодорхойлж тусгасан байна.....5 А.2.1. Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны эрхзүйн орчныг шинэчлэх, сайжруулах шаардлагатай байна.....5-7 А.2.2. Төрийн сангийн чиг үүргийг шинэчлэн сайжруулах бодит хэрэгцээ шаардлага байна.....8 А.3.1.Сумдын төрийн сангийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг холбогдох заавар журмын дагуу боловсруулж, баталж ажиллаагүй байна.....8-10 А.3.2. Зарим сумын төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэнд ажил хавсруулан гүйцэтгүүлсэн байна.....9-11 А.4.2. Аймаг, сумдын төрийн сангийн үйл ажиллагааг үр нөлөөтэй явуулах бодлогын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөлт хангалтгүй, биелэлтийг бодитой үнэлж чадаагүй байна.....11-13 Бүлэг 2 Б.1Төрийн сангийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулах шаардлагатай байна. Б.1.1. Төрийн сангийн төлбөр тооцоог гүйцэтгэхдээ холбогдох журмын зарим заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.....13-15 Б.1.2.Төрийн сангийн нэгдсэн данс болон мөнгөн хөрөнгийн удирдлага зохих түвшинд хэрэгжсэн байна.....16-17 Б.1.3. Төсвийн хэрэгжилтийг хангалттай хэмжээнд зохион байгуулж ажилласан байна.....18-19 Б.2.1. Системийг хэрэглэхэд ойлгомжтой боловч, шаардлагатай үйл ажиллагааны хамрах хүрээг бүрэн хамарч чадаагүй байна.....19-22 Б.2.2. Системийн программ хангамж, мэдээллийн технологи аюулгүй ажил хангагдсан байна.....22-23 Б.3.1. Төлбөр тооцооны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлсэн боловч биелэлтийг хангуулж ажиллаагүй байна.....23-24 Б.3.2. Төсвийн хэрэгжилт мөнгөн хөрөнгийн удирдлагад тавих дотоод хяналт хангалтгүй байна.....24-25 Дүгнэлт.....26 Зөвлөмж.....27 Байгууллагын санал.....28 Баталгаажуулсан гарын үсэг.....29
--	--

Товчилсон үгийн тайлбар

[illegible]

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт:

Төсвийн байнгын хорооны 2017 оны “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов А/06 дугаар тушаалаар батлагдсан Үндэсний аудитын газрын 2018 онд аудит хийх төлөвлөгөө, аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны аудитын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Төрийн сангийн тогтолцоо, 2017 оны үйл ажиллагааны үр дүн”-д аудит хийж үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулах, үйл ажиллагааны үр дүнг сайжруулах санал, зөвлөмж өгөх, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Хамрах хүрээ:

Энэхүү аудитад аймаг, сумын Төрийн сангийн 2017 оны үйл ажиллагааг хамруулж аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн үйл ажиллагааны болон дотоод хяналтын ажлын төлөвлөгөө, тайлан, төрийн сангийн төлбөр тооцооны баримтууд, бусад холбогдох баримт материалыг хамруулав.

Эрсдэлийн үнэлгээ:

Аудитын төлөвлөлтийн явцад судалсан баримт материалд үндэслэн хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн ерөнхий эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, ажлын тайлан, баримт материалд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашигласны зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын багийн бүрэлдэхүүн:

Аудитыг ахлах аудитор Д.Назгүл ахалж, аудитор Р.Баярмаа нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг 2018 оны 08 дугаар сарын 13-наас эхлэн 11 дүгээр сарын 02-ны хооронд хийж гүйцэтгэв.

Бүлэг 1

*Төрийн сангийн эрхзүйн орчин, тогтолцоог оновчтой
зохион байгуулах шаардлага байна.*

Оршил

Тус аймагт аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс болон 13 сум, 1 тосгоны санхүүгийн албад төрийн сангийн 15 нэгж үйл ажиллагаа явуулж байна. Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумын санхүүгийн албадад нийт 36 мэргэжилтэн ажиллаж байгаагаас төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн 16 байна.

Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумуудын төрийн сан нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлж ажилладаг байна.

Аймгийн төрийн сан нь аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс дотор, сумын төрийн сангийн нэгж нь сумын Засаг даргын тамгын газрын Санхүүгийн албанд харьяалагдаж үйл ажиллагаа явуулж байна.

А.1. Төрийн сангийн эрхзүйн орчин, тогтолцоог оновчтой зохион байгуулах шаардлага байна.

А.1.1.Төрийн сангийн чиг үүргийг холбогдох хуульд тодорхойлж тусгасан байна.

Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлд төрийн сангийн тогтолцоо нь төв, аймгийн, сум дүүргийн сан, төрийн захиргааны байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогчоос бүрдэнэ гэж заажээ.

Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт төрийн сангийн хэрэгжүүлэх үндсэн 8 нийтлэг чиг үүргийг тодорхойлсон байна.

Төсвийн тухай хуулийн 36.2-т "... аймаг, сумын төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд байна" гэж заасны дагуу аймгийн Төрийн сан аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст, сумдын төрийн сан нь сумын Санхүүгийн албанд харьяалагдаж үйл ажиллагаа явуулж байна.

Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан төрийн сангийн нийтлэг чиг үүрэг, Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар"-т тусгасан нийтлэг чиг үүрэг болон орон нутгийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой төсвийн төлөвлөлт, орон нутгийн орлогын төлөвлөлт, хэрэгжилт, төсвийн байгууллага, аж ахуйн нэгжийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих зэрэг чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаж байна.

Аймаг, сумын төрийн санг тухайн шатны ЗДТГ-ын дэргэд бие даасан нэгж болгон чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэх зохистой бүтэц бий болгож ажиллуулах нь зүйтэй байна.

А.2. Төрийн сангийн тогтолцоог чиг үүрэгтэй уялдуулж шинэчлэн сайжруулах шаардлага байна.

А.2.1. Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны эрхзүйн орчныг шинэчлэх, сайжруулах шаардлагатай байна.

Төсвийн тухай хуулийн 36.3-т “сум, дүүрэгт нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх санхүүгийн алба байгуулж болно” гэсний дагуу Монгол Улсын Засгийн газрын 2014 оны “Сумдад санхүүгийн алба байгуулах тухай” 326 дугаар тогтоолоор сумдад үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагуудад санхүү, нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн үйлчилгээ хүргэх, сумын төсөв, санхүү, эдийн засаг, хөгжлийн бодлогын төлөвлөлт хариуцсан Санхүүгийн албыг байгуулж ажиллуулсан байна.

Төрийн сан нь аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс дотор, сумын төрийн сангийн нэгж нь сумын санхүүгийн алба дотор харьяалагдаж ажиллахаар хуульчилж зохицуулсан нь төрийн сангийн нийтлэг чиг үүргийн хэрэгжилтийг хангах, төрийн сангийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл бололцоо хангалтгүй байх нөхцөл бүрдсэн гэж үзэх үндэстэй ба төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд орон нутгийн удирдлагуудаас хараат бус ажиллах нөхцөл байдал алдагдсан байгаа нь аудитаар ажиглагдсан.

Хөдөө сумуудад төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн төсөвт байгууллагын нягтлан бодогч нарын хамт нэг албанд ажиллаж байна.

Төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтод тусгагдаагүй, үндсэн чиг үүрэгт хамааралгүй давхар ажил хариуцуулдаг зөрчил байна.

Баяннуур, Бугат, Толбо сумын санхүүгийн албаны дарга, төрийн сангийн төлөөлөгч, төсөвт байгууллагын нягтлан бодогч 5-6 ажилтан нэг өрөөнд байрлаж, ажлаа явуулж байна.

Бугат сумын санхүүгийн албаны дарга, төрийн сангийн төлөөлөгч нар нэг компьютерээр гүйлгээ хийж, баталгаажуулж байна.

Цэнгэл сумын санхүүгийн алба нь ашиглалтын хугацаа дууссан хуучин компьютер, принтер ашиглаж, төрийн сангийн төлөөлөгчийг сейф, ширээгээр хангаж өгөөгүй байна.

Энэ нь сумын ЗДТГ-аас төрийн сангийн компьютер, техник хэрэгслийг шинэчлэх, аюулгүй байдлыг хангах, ажиллах нөхцөл боломжийг сайжруулах талаар анхаарал хандуулахгүй байгааг харуулж байна.

Сумын төрийн сангийн нэгж нь аймгийн төрийн санд, аймгийн төрийн сан нь Төв төрийн санд харьяалагдаж, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс тусдаа газар, хэлтэс болж ажиллах эрхзүйн зохицуулалт шаардлагатай байгааг дээрх нөхцөл байдал харуулж байна.

Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3 , 36.4, 36.5 дахь хэсэгт заасны дагуу сумуудад санхүүгийн алба байгуулан ажиллуулснаар нягтлан бодогчийн орон тоог хэмнэж ажиллаж байгаа боловч адилхан төсөвтэй аймгийн төвийн нэг төсөвт байгууллагад нэг нягтлан бодогч ажиллаж байгаа бол хөдөө сумуудад 2-4 байгууллагын нягтлан бодох бүртгэлийг нэг нягтлан бодогч хариуцан ажиллаж байгаа нь ажлын ачаалал ихтэй, шударга биш явдал байна.

Сумууд 6-12 төсөвт байгууллагатай, 3-5 нягтлан бодогчтой ба зарим сумдад нэг нягтлан бодогч 4 байгууллага хариуцан ажиллаж байгаа нь ажлын ачаалал их байгаагаас нягтлан бодох бүртгэл хөтлөлт, анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналт сулрах эрсдэлтэй байгаа нь ажиглагдсан.

Сумуудын төсөвт байгууллага хариуцан ажиллаж байгаа нягтлан бодогчдын судалгаа

Судалгаа №1

№	Сумууд	Төсөвт байгууллагын тоо	Нягтлан бодогчийн тоо	Хариуцсан байгууллагын тоо			
				4	3	2	1
1	Алтай	6	3			3	
2	Алтанцөгц	6	2	1		1	
3	Баяннуур	8	5			3	2
4	Бугат	6	2		2		
5	Булган	9	3		3		
6	Буянт	6	3			3	
7	Дэлүүн	7	3	1		2	1
8	Ногооннуур	8	4		2	1	1
9	Толбо	6	2		2		
10	Улаанхус	11	4		3	1	
11	Сагсай	6	4			2	2
12	Цагааннуур	5	4		1		3
13	Цэнгэл	10	4		1	3	1
14	Өлгий	35	33			2	31
	Дүн	129	76	2	14	21	41

Эх сурвалж: Сумын санхүүгийн албанаас авсан судалгааг нэгтгэв.
/Жич: ОНХС, СХСанг байгууллагын тоонд оруулаагүй.

Дээрх судалгаанаас үзэхэд дөрвөн байгууллага хариуцсан 2, гурван байгууллага хариуцсан 14, хоёр байгууллага хариуцсан нягтлан бодогч 21 хүн ажиллаж байна. Нэг байгууллага хариуцсан нягтлан бодогч 41 байгаагийн 31 нь аймгийн төвийн Өлгий сумд ажиллаж байна.

Сумуудад санхүүгийн алба байгуулагдснаар төсөвт байгууллагуудын дарга, нярав болон тухайн байгууллагыг хариуцсан нягтлан бодогч нарын хоорондын ажил хэргийн уялдаа, эргэх холбоо алдагдаж, санхүүгийн хяналт сулрах хандлага ажиглагдаж байна.

Зарим сумуудад төсөвт байгууллагын санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлт, хоол, үдийн цайны зардлын гүйцэтгэл, хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт суларч, байгууллагын үндсэн хөрөнгө, бараа материалын тооцоо алдагдах, нөхцөл бүрдсэн байна.

А.2.2. Төрийн сангийн чиг үүргийг шинэчлэн сайжруулах бодит хэрэгцээ шаардлага байна.

Төрийн сангийн чиг үүргийг холбогдох хуульд оновчтой тодорхойлсон боловч зарим чиг үүрэг Санхүүгийн хэлтсийн чиг үүрэгтэй давхцаж байгаа тул төрийн санг Санхүү хэлтсээс тусдаа бие даасан нэгж болгон зохион байгуулж чиг үүргийг шинэчлэн сайжруулах бодит хэрэгцээ байна.

А.3. Хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх зохистой бүтцийг бий болгоогүй байна.

А.3.1. Сумдын төрийн сангийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг холбогдох заавар журмын дагуу боловсруулж, баталж ажиллаагүй байна.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс нь аймаг, сумын төрийн сангийн үйл ажиллагааг Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан чиг үүргийн дагуу зохион байгуулж ажиллажээ.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь хэлтсийн дарга, төсвийн ерөнхий нягтлан бодогч, бүртгэлийн мэргэжилтэн, дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн, төсвийн мэргэжилтэн, боловсрол соёлын салбарын төсөв хариуцсан мэргэжилтэн, төсвийн орлого хариуцсан мэргэжилтэн тус бүр 1, төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн 2, нийт 9 орон тоогоогоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

Санхүү төрийн сангийн хэлтсийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолт боловсруулах заавар”, Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”-ын дагуу 2017 оны 8 дугаар сард шинэчлэн боловсруулж ЗДТГазрын даргаар батлуулж, мөрдөж ажиллажээ.

Ажлын байрны тодорхойлолтод дээрх жишиг зааврын дагуу ажил үүргийг бүрэн тусгасан байна.

Бүртгэлийн мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”-ын 1.3-т “Бүртгэлийн мэргэжилтний ажил үүрэг:1.3.10-т Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуй нэгж байгууллагын банк дахь дансны үлдэгдлийг хагас бүтэн жилээр тулган баталгаажуулах” гэсэн үүргийг тусгаагүй байна.

Санхүү, төрийн сангийн хэлтэс нь мэргэжилтнүүдийн тухайн онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг авч, үр дүнгийн гэрээг дүгнэж ажилласан байна.

Сумдын төрийн сангийн ажилтнуудын ажил үүргийг орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг зааврын дагуу ажлын байрны тодорхойлолтод бүрэн тусгасан эсэхийг шалгаж үзэхэд Алтанцөгц, Буянт, Сагсай, Өлгий сумдын санхүүгийн албаны дарга нарын ажлын байрны тодорхойлолтыг дээрх жишиг зааврын дагуу боловсруулсан боловч 1-7 ажил үүргийг тусгаагүй үлдээсэн байна.

Алтай, Баяннуур, Бугат, Булган, Дэлүүн, Ногооннуур, Толбо, Улаанхус, Цэнгэл сумдын санхүүгийн албаны дарга нарын ажлын байрны тодорхойлолтыг жишиг зааврын дагуу боловсруулаагүй байна.

Сагсай сумын төрийн сангийн мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтыг холбогдох жишиг зааврын дагуу чиг үүргийг бүрэн тусгаж боловсруулж баталсан байна.

Улаанхус, Цагааннуур, Өлгий сумдын төрийн сангийн төлөөлөгчдийн ажлын байрны тодорхойлолтыг зааврын дагуу боловсруулсан боловч 3-5 чиг үүргийг тусгаагүй байна.

Алтанцөгц, Баяннуур, Булган, Буянт, Дэлүүн, Ногооннуур, Толбо сумдын төрийн сангийн мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтод жишиг зааварт заасан чиг үүргийг бүрэн тусгаж, батлаагүй байна.

Бугат сумын төрийн сангийн төлөөлөгчийн ажлын байрны тодорхойлолтод нягтлан бодогчийн ажил үүргийг тусгаж, Алтанцөгц, Ногооннуур сумдын төрийн сангийн төлөөлөгчдийн ажлын байрны тодорхойлолтод нэг ажил үүргийг зорилт тус бүрт давтан оруулж жишиг зааврыг мөрдөж ажиллаагүй байна.

Цэнгэл сумын төрийн сангийн мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан батлаагүй байна.

Алтай, Баяннуур, Бугат, Буянт, Ногооннуур, Сагсай, Толбо сумдын санхүүгийн албаны дарга, Алтай, Алтанцөгц, Баяннуур, Бугат, Булган, Буянт, Ногооннуур, Өлгий сумын төрийн сангийн төлөөлөгчдийн ажлын байрны тодорхойлолтын бүрдэл дутуу Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолт боловсруулах заавар”-ын стандарт маягтын дагуу хийгээгүй байна.

Аудитын дүнгээр сумын санхүүгийн албаны дарга, төрийн сангийн мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтыг Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”, Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолт боловсруулах заавар”-ын дагуу нэг заавар стандартаар хариуцаж ажиллах чиг үүргийг бүрэн тусгаж шинэчлэн боловсруулж, батлуулж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэв.

А.3.2. Зарим сумын төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэнд ажил хавсруулан гүйцэтгүүлсэн байна.

Төрийн сан нь аймаг, сумдын Санхүү, төрийн сангийн хэлтэс, санхүүгийн албаны дотор ажиллах хууль эрхзүйн зохицуулалт байгаатай холбоотой орон нутагт Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн холбогдолтой бусад хууль эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангах, орон нутгийн тусгай сангуудын мөнгөн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх, орон нутгийн төсвийн төсөл боловсруулах, татварын орлогын бүрдүүлэлт, тайлан тэнцэлд хяналт тавих зэрэг төрийн сангийн үндсэн чиг үүрэгт хамааралгүй ажлуудыг давхар гүйцэтгэж ирсэн байна.

Зарим сумын төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн нарт төрийн сангийн үйл ажиллагааны чиг үүрэгт хамааралгүй ажлыг хавсран гүйцэтгүүлсэн байна.

Тухайлбал: Баяннуур, Дэлүүн, Ногооннуур, Өлгий сум болон Цагааннуур тосгоны төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтнүүдэд Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн санг хариуцуулж 2 дугаар гарын үсэг зурж ажилласан байна.

Судалгаа №2

№	Сумууд	Төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэний хавсран гүйцэтгэж байгаа ажил	
		Сум хөгжүүлэх сан	Орон нутгийн хөгжлийн сан
1	Баяннуур		1
2	Дэлүүн	1	1
3	Ногооннуур	1	
4	Цагааннуур	1	1
5	Өлгий	1	1

/Эх сурвалж: Сумуудын санхүүгийн албанаас авсан судалгаа/

Аудитын дүнгээр дээрх сумын төрийн сангийн мэргэжилтнүүдэд төрийн сангийн чиг үүргээс гадуур давхар ажил хариуцуулсан зөрчлийг арилгуулах талаар албан шаардлага хүргүүлэв.

А.4. Төрийн сангийн үйл ажиллагааг үр нөлөөтэй явуулах бодлого, стратеги байхгүй байна.

А.4.2. Аймаг, сумдын төрийн сангийн үйл ажиллагааг үр нөлөөтэй явуулах бодлогын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөлт хангалтгүй, биелэлтийг бодитой үнэлж чадаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 37.2-т заасны дагуу Төрийн сан нь тухайн шатны Засаг даргын тамгын газрын дэргэд байхаар хуульчлагдсан тул тухайн шатны ЗДТГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөнд төрийн сангийн үйл ажиллагааг үр нөлөөтэй явуулах бодлогын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж ажиллах ёстой.

Аймаг, сумдын ЗДТГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөнд төрийн сангийн үйл ажиллагааг үр нөлөөтэй явуулах бодлогын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж ажилласан эсэх талаар шалгахад дараах байдалтай байна.

-Аймгийн Засаг даргын 2013 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 113 дугаар захирамжаар аймгийн ЗДТГ-ын 2013-2016 он хүртэлх үйл ажиллагааны дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, стратеги төлөвлөгөө боловсруулснаас хойш аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагааны дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна.

-Сумдын ЗДТГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөнд төрийн сангийн үйл ажиллагааг үр нөлөөтэй явуулах бодлогын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө байхгүй байна.

- Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт төрийн сангийн үйл ажиллагааны талаар дараах ажлуудыг төлөвлөж ажилласан байна.Үүнд:

- Урсгал төсвийг үр ашигтай зарцуулж, батлагдсан төсөв, орон тооны хүрээнд үйл ажиллагаа явуулахад тавих хяналт, хариуцлагыг сайжруулах
- Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэн үр ашиггүй зардлыг бууруулах
- Төрийн сангаас хийгдэх санхүүжилт, төлбөр тооцоог шуурхай гүйцэтгэж, төрийн сангийн төлбөр тооцооны гүйцэтгэлд байнгын хяналт тавьж ажиллах
- Төсөвт байгууллагуудаас үзүүлж байгаа үйлчилгээний төрөл, төлбөрийг нэгдсэн хяналтад оруулна. Төрийн сангийн дотоод хяналтыг эрсдэл суурилсан төлөвлөгөөт болон Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системээр хэрэгжүүлэх
- Батлуулсан хуваарийн дагуу төсвийн, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын анхан шатны бүртгэл хөтлөлтөд хяналт тавьж, хөтлөлтийн түвшинг нэмэгдүүлэх
- Санхүүгийн программын ашиглалтын талаар судалгаа хийж, программгүй газруудыг программтай болгож, ашиглалтын байдлыг сайжруулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

2017 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт, хүрсэн түвшинг 100 хувийн биелэлттэй гэж гаргасан байна.

- Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлд тухай бүрт нь хяналт тавин сар бүрийн орлогын гүйцэтгэлийн мэдээг Татварын хэлтэстэй тулган баталгаажуулж, мэдээллийг хүргүүлэн ажилласан.

Төсвийг үр ашигтай зарцуулах чиглэлээр сум байгууллагуудад албан тоот хүргүүлж, сумдын удирдах ажилтнуудын зөвлөгөөнд тодорхой ярьж үүрэг даалгавар өгчээ.

-Төсвийг хэмнэх зорилгоор төрийн сангийн хяналтыг сайжруулж, бүлэг хооронд шилжүүлэн зарцуулах зөвшөөрөл олгохгүй, хэмнэлттэй зардлуудыг хүрэлцэхгүй байгаа бусад зардалд шилжүүлэх тухай байгууллагуудын хүсэлтийг судлан шаардлагатай зардлуудыг төсвийн тодотголд тусгаж өгсөн.

-Төсвийн санхүүжилтийг санхүүжилт орж ирсэн өдрөөс хойш 2 хоногийн дотор олгож, нэмэлт дансны орлогын зарцуулах эрхийг өдөртөө багтааж Сангийн яаманд хүргүүлэн зарцуулах эрхийг нээж, Төрийн сангийн төлбөр тооцоонд долоо хоногт 2 удаа системийн хяналт хийж байна.

-Төрийн сангийн дотоод хяналт, эрсдэлд суурилсан төлөвлөгөөт хяналтыг бүх сумдад жилд нэг удаа хийсэн байна. 2017 онд Алтай, Бугат, Ногооннуур, Сагсай, Цагааннуур, Буянт, Булган, Дэлүүн, Толбо, Өлгий, Баяннуур, Алтанцэгц сумдын төрийн сангийн үйл ажиллагааг шалган зааварчлах ажил хийгджээ.

-2016 онд анхан шатны бүртгэл хөтлөлт 90.6%, нягтлан бодох бүртгэл хөтлөлт 91.2% байсан бол 2017 оны жилийн эцсийн байдлаар төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын анхан шатны бүртгэл хөтлөлт 91.1%, нягтлан бодох бүртгэл хөтлөлт 91.8%-д хүрсэн ахицтай байна.

-Төсвийн байгууллагуудын санхүүгийн программ ашиглалт 2017 онд 92%-д хүрсэн байна.

Дээрх төлөвлөсөн ажлуудын хэрэгжилтийн байдлыг судалж үзэхэд төсвийн байгууллагууд Сангийн яамнаас хянаж ирүүлсэн орон тооны хязгаараас хэтрүүлсэн орон тоо ажиллуулсан, өр авлагыг нэмэгдүүлсэн, санхүүгийн программ ашиглалт хангалтгүй, төлбөрийн хүсэлт, хяналтын хуудсыг санхүүгийн программаар гаргаж бүрэн хэвшээгүй зөрчил дутагдал оршсоор байна.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс 2017 онд хийх ажлын төлөвлөгөө боловсруулж, батлуулж ажиллаагүй, аймгийн Төрийн сангаас сумуудын төрийн сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналтаар илэрсэн алдаа, зөрчлийн дүнгээр өгсөн зөвлөмж, түүний биелэлтийг шалгасан талаар материал байхгүй байна.

Бүлэг 2

Төрийн сангийн үйл ажиллагааны үр дүнг
сайжруулах шаардлага байна.

Б.1. Төрийн сангийн төлбөр тооцоо, төсөв, мөнгөн хөрөнгийн удирдлага, зохицуулалтыг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж ирсэн байна.

Б.1.1. Төрийн сангийн төлбөр тооцоог гүйцэтгэхдээ холбогдох журмын зарим заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Төсвийн орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээг хийх нь төрийн сангийн үндсэн чиг үүрэг юм.

Аудитаар аймгийн төрийн сангийн үйлчлүүлэгч 6 байгууллага, Өлгий сумын 14 байгууллага, Баяннуур, Бугат, Буянт, Ногооннуур, Толбо, Сагсай, Улаанхус, Цэнгэл сумуудын бүх төсөвт байгууллагуудыг түүвэрт хамруулж, нийт 80 байгууллагын төрийн сангаар дамжин хийгдсэн төлбөр тооцоог хүчин төгөлдөр анхан шатны баримтаар гүйцэтгэж байгаа эсэх болон баталгаажуулалтыг үнэн зөв гүйцэтгэж байгаа эсэхийг шалгалаа.

Нийт 80 байгууллагын 7717 төлбөрийн хүсэлтийг түүвэрлэн шалгаж Б.1-1-1 маягтаар нэгтгэхэд төлбөрийн хүсэлтийн иж бүрдлийн талаар дараах үр дүн гарч байна.

Б.1-1-1

№	Төлбөрийн хүсэлтийн иж бүрдэлийн талаар:	Шаардлага хангасан		Шаардлага хангаагүй	
		Баримтын тоо	Хувь	Баримтын тоо	Хувь
1	Төлбөрийн хүсэлт, хяналтын хуудсыг санхүүгийн програмаар хийсэн байна уу?	4089	53.0	3628	47.0
2	Гарын үсгийн баталгааны маягтын дагуу төлбөрийн хүсэлтийг зурсан байна уу?	7717	100.0		
3	Нэг, хоёрдугаар гарын үсэг зурагдсан байна уу?	7608	98.6	109	1.4
4	Аль нэг гарын үсэг дутуу байна уу?	7608	98.6	109	1.4
5	Байгууллагын тамга төлбөрийн хүсэлтэнд дарагдсан байна уу?	7655	99.2	62	0.8
6	Засвартай төлбөрийн хүсэлтээр төлбөр тооцоог гүйцэтгэсэн байна уу?	7622	98.8	95	1.2
7	Хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангиллыг зөрүүлж зарлагын гүйлгээ хийсэн байна уу?	7670	99.4	47	0.6
8	Нэр занс зөрүүтэй буцаж орж ирсэн гүйлгээний нотлох баримтыг нягтлан, төлбөрийн хүсэлтэнд хавсаргасан байна уу?		0.0		0.0
9	Төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн төлбөрийн хүсэлтийг ажлын 3 хоногоос хэтрүүлж гүйцэтгэсэн байна уу?	7620	98.7	97	1.3
10	Төлбөр тооцоог баталгаажуулахдаа ажлын 3 хоногт багтаан гүйцэтгэсэн байна уу?	7620	98.7	97	1.3
11	Төлбөрийг хүсэлтэнд мэргэжилтний гарын үсэг, тэмдэг дарагдсан байна уу?	7616	98.7	101	1.3
12	Мемориалын баримтыг дараагийн ажлын өдөрт багтаан бүрдүүлбэрийн дагуу хянаж, баталгаажуулсан байна уу?	2058	26.7	5659	73.3
13	Мемориалын баримтыг архивын нэгж болгон боловсруулж, архивын ажилтанд хүлээлгэн өгч байна уу?	2058	26.7	5659	73.3

Төлбөрийн хүсэлтийн иж бүрдлээр шалгахад нэг, хоёрдугаар гарын үсэг дутуу, байгууллагын тамга төлбөрийн хүсэлтэд дарагдаагүй, хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангиллыг зөрүүлж зарлагын гүйлгээ хийсэн, САГ-2018-03-СА

төлбөрийн хүсэлтийг төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн ажлын 3 хоногоос хэтрүүлж гүйцэтгэсэн, төлбөр тооцоог баталгаажуулахдаа ажлын 3 хоногт багтаан гүйцэтгээгүй, төлбөрийн хүсэлтэд мэргэжилтний гарын үсэг, тэмдэг дарагдаагүй зэрэг зөрчлүүд 0,6-1,4 хувьтай байна.

Түүвэрт хамруулж шалгасан төлбөрийн хүсэлт, хяналтын хуудасны 47 хувь нь санхүүгийн программаар хийгдээгүй, 73,3 хувийг дараагийн ажлын өдөрт багтаан бүрдүүлбэрийн дагуу хянаж баталгаажуулаагүй, архивын нэгж болгон боловсруулж, архивын ажилтанд хүлээлгэн өгөөгүй байна. Амлалтын бүртгэлийг аймгийн хэмжээнд хөтлөөгүй.

Төрийн сангийн нэгжээр нь авч үзвэл: Цэнгэл, Толбо сумын төрийн сан 2017 онд төлбөрийн хүсэлт, хяналтын хуудсыг 100 хувь санхүүгийн программаар хийгээгүй ба энэ үзүүлэлт Улаанхус сумд 44,4 хувьтай, Ногооннуур сумд 43,6 хувьтай, Бугат сумд 63,1 хувьтай, Өлгий сумд 23,7 хувьтай, Буянт сумд 12,4 хувьтай байна.

“Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 11.1-д “Төрийн сан өдөр тутмын төлбөрийн баримтыг тухайн өдрийн зарлагын гүйлгээний жагсаалттай дараагийн ажлын өдөрт багтаан хянаж тулгасан байна”, 11.2-т “Төрийн сангийн өдрийн мемориалын баримтыг архивын стандартын дагуу архивын нэгж үүсгэнэ” гэсэн заалтыг аймгийн төрийн сан, Өлгий, Бугат, Баяннуур, Буянт, Ногооннуур, Улаанхус, Цэнгэл сумын төрийн сан мөрдөж ажиллаагүй, 2017 оны төрийн сангийн мемориалын баримтыг архивын нэгж үүсгэж зохих журмын дагуу холбогдох архивын ажилтандаа хүлээлгэж өгөөгүй байна.

Бугат, Баяннуур, Буянт, Ногооннуур, Улаанхус, Цэнгэл сумын төрийн сангууд зарлагын гүйлгээний жагсаалтыг сараар үдэж хавтасласан байна. Аймгийн төрийн сан, Өлгий сумын төрийн сан 2017 оны сүүлийн хагас жилийн мемориалын баримт үдэгдээгүй байсныг аудитын явцад үдүүлсэн.

Сагсай сумын төрийн сан зарлагын гүйлгээний баримтыг зохих журмын дагуу өдөр бүр архивын нэгж үүсгэж, үдэж хавтаслан, санхүүгийн албаны дарга хянаж баталгаажуулж, сумын ЗДТГ-ын архивын ажилтандаа хүлээлгэн өгсөн байна. Толбо сумын төрийн сан нь зарлагын гүйлгээний жагсаалтын дагуу өдөр бүр хэвлэн авсан боловч үдэж хавтаслаж, хянаж баталгаажуулаагүй байна.

Б.1-1-1 маягтаар хяналтын хуудасны иж бүрдлийг шалгаж нэгтгэхэд дараах дүнтэй байна.

Б.1-1-1

№	Хяналтын хуудсын иж бүрдэлийн талаар:	Шаардлага хангасан		Шаардлага хангаагүй		Үүнээс баталгаажуул аагүй баримтын тоо	Хувь
		Баримтын тоо	Хувь	Баримтын тоо	Хувь		
1	Анхан шатны баримттай нэг бүрчлэн тулгаж, тэмдэглэгээ хийсэн байна уу / нэхэмжлэх, зарлагын баримт, гэрээ, тендерийн баримт бичиг, амлалтын бүртгэл, ажилтнуудын цагийн бүртгэл, цалингийн хүснэгт, цалин шилжүүлсэн арилжааны банкны жагсаалт гэх мэт/	19810	98.2	361	1.8	5627	27.9
2	Нэр болон данс, эдийн засгийн ангилал зөрүүтэй, данс андуурч гарсан зарлагын гүйлгээнд / хасах / мемориалын баримт үйлдсэн эсэх	45	64.3	25	3.6		
3	Засвартай хяналтын хуудасаар төлбөр тооцоог гүйцэтгэсэн байна уу	7717	100.0		0.0		
4	Жижиг мөнгөн сангийн кассын тайланг хяналтын хуудсанд хавсаргасан байна уу	Бүх байгууллага хавсаргаагүй байна.					

Түүвэрт хамруулсан төлбөрийн хүсэлт, хяналтын хуудсыг анхан шатны баримттай нэг бүрчлэн тулгаж, тэмдэглэгээ хийсэн байдлыг шалгахад анхан шатны нийт баримтын 27,9 хувийг хянаж, тэмдэглэгээ хийгээгүй байна.

Анхан шатны нийт баримттай харьцуулахад шаардлага хангаагүй баримт 1,8 хувийг эзэлж байна. Түүвэрт хамруулсан байгууллагууд жижиг мөнгөн сангийн кассын тайланг хяналтын хуудсанд хавсаргаагүй байна.

Аудитаар аймгийн төрийн сангийн 2017 оны 3, 6, 9, 10, 11, 12 дугаар сарын, Баяннуур, Бугат, Буянт, Ногооннуур, Толбо, Улаанхус, Цэнгэл, Өлгий сумуудын төрийн сангийн 2017 оны 1-12 дугаар саруудын мемориалын баримтыг тулган баталгаажуулж шалгахад 321 ш баримт дутагдсан. /Судалгаа №3/

Судалгаа №3

№	Төрийн сангийн нэр	Баримтын тоо
1	Баяннуур сум	114
2	Бугат сум	44
3	Буянт сум	36
4	Ногооннуур сум	22
5	Толбо сум	2
6	Улаанхус сум	5
7	Цэнгэл сум	12
8	Өлгий сум	86
	Дүн	321

/Эх сурвалж:Аудитаар сумуудад хэрэгжүүлсэн тулган баталгаажуулалт/

Дээрх байдал нь “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 11.1, 11.2-дахь заалтуудыг мөрдөж ажиллаагүй, төрийн сангийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналт сул, ажлын хариуцлагагүй байдалтай холбоотой байна.

Аймгийн төрийн сан болон түүвэрт хамруулсан сумуудын төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтний тэмдгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг шалгаж Б.1-1-2 маягтаар нэгтгэлээ.

Бугат, Буянт, Улаанхус сумын төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтний тэмдгийг зориулалтын дагуу сейфэд хадгалсан боловч лацгүй байна. Аймгийн төрийн сан, Баяннуур, Ногооннуур, Сагсай, Толбо, Өлгий, Цэнгэл сумуудын төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтнүүдийн тэмдгийн хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна. Тухайлбал: Цэнгэл сумын төрийн сангийн мэргэжилтэн сейфгүй, бусад сумуудын мэргэжилтнүүд ширээний цоожгүй шургуулгад хадгалж байна.

Төрийн санд аймгийн болон сумуудын төрийн санд ашиглагдаж байгаа тэмдгийн нэгдсэн бүртгэл байна. Сумууд 2017 онд ашиглах төрийн сангийн тэмдгийн нэгдсэн бүртгэлийг 2017 оны 1-р сард шинэчилж аймгийн Төрийн санд хүргүүлсэн байна.

Аймгийн төрийн сан Баян-Өлгий аймгийн төрийн сангийн тамга тэмдгийн нэгдсэн бүртгэлийг 2017 онд ашигласан ба 2018 онд ашиглах хэрэглэгчийн нэрсийн хамт гаргаж 2018 оны 1 дүгээр сарын 05-нд Төв төрийн санд хүргүүлж ажилласан байна.

Аймгийн төрийн санд нууцын зэрэглэлтэй байгууллагын бүртгэл байхгүй байна. Тус аймагт нууцын зэрэглэлтэй 7 байгууллага байгаагаас аймгийн төрийн сангаар 5 байгууллага, Улаанхус сумын төрийн сангаар 1, Цагааннуур тосгоны төрийн сангаар 1 байгууллага гүйлгээ хийлгэдэг ба нууцын зэрэглэлтэй байгууллагууд нь нууцын тэмдэг дарсан баримт ирүүлж байгаагүй тул нууцын талаар холбогдох зохицуулалт хийх шаардлага одоогоор гараагүй байна.

Б.1.2. Төрийн сангийн нэгдсэн данс болон мөнгөн хөрөнгийн удирдлага зохих түвшинд хэрэгжсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 5.9-д “Төрийн сан өөрийн салбар нэгжийн бүртгэлд байгаа бүртгэлийн дансны талаар бүртгэл хөтөлж архив үүсгэнэ” гэсэн боловч аймгийн төрийн сан аймгийн хэмжээнд төрийн санд байгаа дансны талаар мэдээллийн сан, архив үүсгэж ажиллаагүй байна.

2017 онд аймаг, сумын төрийн санд нийт 691 данс байршиж байсны 246 данс аймаг, сумдын орон нутгийн төсвийн орлогын данс байна. Эдгээр дансууд журамд заасан зориулалтаар ашиглагдаж байгаа юм байна.

Аймгийн дүнгээр 2017 онд давхардсан тоогоор бүртгэлийн 2768 дансаар 46137 ширхэг гүйлгээ буюу 136250,7 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн байгаа нь сард дунджаар 3845 ширхэг, өдөрт дунджаар 175 ширхэг гүйлгээ хийгдсэн байна.

Б.1-1-3 маягтаар нэгтгэж үзэхэд 2017 онд 285 ширхэг гүйлгээг орлого бууруулж хийсэн байна. Сангийн яамнаас 2017 онд хийсэн шалгалтын тайланд 27 гүйлгээг журам зөрчиж гүйцэтгэсэн гэснийг тодруулж шалгахад холбогдох журмыг зөрчиж татварын буцаан олголтыг буруу эдийн засгийн ангиллаар олгосон байна.

Түүвэрт хамрагдсан төрийн сангуудад бүртгэлтэй дансуудын гарын үсгийн баталгааны бүрдэлд хийсэн хяналтаар:

Аймгийн төрийн сан болон Сагсай, Толбо сумын төрийн сан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.3-т “Төсвийн байгууллага гарын үсгийн баталгааг энэхүү журмын 3 дугаар хавсралтын ТТ-3 маягтаар үйлдэн нотариатаар батлуулан 1, 2 дугаар гарын үсэг зурах эрх олгосон болон томилогдсон шийдвэр, энэхүү журмын 7.2-т заасан зөвшөөрлийн хамт харьяа Төрийн санд хүргүүлнэ” гэж заасны дагуу бүрдүүлсэн гарын үсгийн баталгааны маягтыг хүлээн авсан байна.

Бугат, Буянт, Улаанхус, Ногооннуур, Цэнгэл, сумууд дээрх журмыг хэрэгжүүлж ажиллаагүй ба Ногооннуур сумын 4 байгууллагын, аймгийн төрийн сангаар гүйлгээ хийлгэдэг 1 байгууллагын гарын үсгийн баталгааны маягт байхгүй байна.

Бугат сумын төрийн сан гарын үсгийн баталгааны маягтыг төрийн сангийн мемориалын баримтад үдсэн боловч зохих журмын дагуу бүрдүүлэлтийг хангаж ажиллаагүй байна.

Оны эцэст тэг үлдэгдэлтэй байх дансуудыг шалгаж үзэхэд Буянт сумын татварын орлогын 911, 912, 922, 941, 952, 975 тоот дансуудын үлдэгдлийг оны эцэст төвлөрүүлээгүй байна. Аймаг, сумдын бусад тэг үлдэгдэлтэй дансуудын үлдэгдлийг сар бүр зохих журмын дагуу төвлөрүүлэн ажиллаж, оны эцэст үлдэгдэлгүй гарчээ.

Аймгийн төрийн санд байгууллагуудын арилжааны банкинд данс нээсэн, хаасан талаар нэгдсэн бүртгэл байхгүй байна. Хаан банк, Төрийн банк, Капитал банк, Голомт банкуудад 2017 онд нээлгэсэн 29 байгууллагын 37 дансыг хаалгасан байна.

2017 оны эцэст арилжааны банкинд зөвшөөрөлгүй данс нээсэн нэг тохиолдол гарсан байна. Бугат сумын ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч ХААН банкинд ЗДТГ-ын нэр дээр данс нээж өгөхийг хүсч 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 241 тоот албан тоот хүргүүлж 5196016849 тоот данс нээлгээд сарын дараа 2017 оны 12 дугаар сарын 14 ний өдрийн 352 тоотоор дансыг хаалгасан байна.

Энэхүү дансаар сумын ангийн орлогын дансанд орох мөнгийг хууль бус шилжүүлэн авч зарцуулсныг 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлж зөрчилд тооцсон байна.

Зөвшөөрөлгүй данс нээсэн байдал нь Сангийн сайд, Монгол банкны ерөнхийлөгчийн 2013 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 24/24/А-9 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монгол банк, банкинд нээх, хаах журам”-ын 3.5-д “Төсвийн байгууллага банкинд данс нээлгэх тухай хүсэлтийг дараах мэдээллийн хамт албан бичгээр Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргад хаяглан ирүүлнэ” Үүнд:

3.5.1.данс нээлгэх шаардлага;

3.5.2.аль банкинд ямар төрлийн данс нээлгэх тухай санал;

3.5.3.данс нээлгэх гэж буй банкны тухай энэхүү журмын 3.2-т заасан мэдээлэл;

3.5.4.шаардлагатай нэмэлт мэдээлэл гэснийг зөрчсөн байна.

Төсвийн орлогын дансны бүртгэлийг орлого бүрдүүлэгч байгууллагуудтай сар бүр тооцоо нийлж баталгаажуулж ажилласан боловч нотлох ажлын баримт байгаагүй. Төсвийн орлогын дансны гүйлгээний залруулга, буцаалтыг оны эхэнд холбогдох журмыг зөрчиж хийж байсан ба Сангийн яамнаас хийсэн шалгалтаар өгсөн заавар, зөвлөгөөний дагуу зохих журмын дагуу төсвийн орлого бүрдүүлэгч холбогдох байгууллага, тооцоо хийж залруулга, буцаалтыг хийдэг болсон байна.

2017 онд аймгийн төрийн санд төсвийн орлого болгох боломжтой орлого байсан эсэхийг судалж үзэхэд: хугацаа дууссан хөрөнгө оруулалт, ажлын захиалагчийн хяналтын зардал, норм, нормативын сан, олон жил болсон барьцааны үлдэгдэл, хэрэгжиж дууссан төсөл хөтөлбөрийн дансны үлдэгдэл байхгүй байна.

Төсвийн хэмнэлтийг төвлөрүүлсэн данс байгаа эсэхийг судлахад: Нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн данс нэртэй данс байгаа ба энэ дансанд тухайн жилийн нэмэлт дансны зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлж ирсэн байна.

Сумуудын төрийн сан дахь барьцаа дансны үлдэгдлийг судалж үзэхэд: Алтай, Буянт, Сагсай, Толбо, Улаанхус, Цэнгэл сумуудын барьцааны дансанд 2016 онд үүссэн 3008,0 мянган төгрөгийн, 2017 онд үүссэн 35002,2 мянган төгрөгийн буюу нийт 38030,2 мянган төгрөгийн үлдэгдэл байна.

2017 онд аймгийн нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн данс 15041,5 мянган төгрөгийн, Баяннуур сумын нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн данс 88,5 мянган төгрөгийн, Булган сумын нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн данс 3760,5 мянган төгрөгийн, Сагсай сумын нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн данс 2210,9 мянган төгрөгийн, Толбо сумын нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн данс 1304,4 мянган төгрөгийн, Улаанхус сумын данс 215,1 мянган төгрөгийн, Цэнгэл сум 55,0 мянган төгрөгийн, Өлгий сум 210,0 мянган төгрөгийн, Цагааннуур тосгон 1380,8 мянган төгрөгийн буюу нийтдээ аймгийн дүнгээр 24266,7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн дансанд байгаа орлогууд нь 2015, 2016 онуудад татан төвлөрүүлсэн орлого бөгөөд энэхүү орлогыг 2018 онд орон нутгийн ерөнхий орлогын дансанд хааж, үлдэгдэлгүй болгохыг зөвлөмж болгов.

Б.1.3. Төсвийн хэрэгжилтийг хангалттай хэмжээнд зохион байгуулж ажилласан байна.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 12 дугаар тогтоолоор аймгийн ТЕЗ-ийн 2017 оны төсвийг, төсөвт байгууллагуудын хуваарийг Засаг даргаар батлуулж ажилласан байна. Аймгийн ИТХ-ын 2017 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 16, 12 дугаар сарын 25-ны өдрийн 25 дугаар тогтоолоор аймгийн төсвийг тодотгож баталсан байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь төсвийн сар, улирлын хуваарийг Засаг даргаар батлуулан ажилласан байна. Аймгийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/07 тоот захирамжаар төсөвт байгууллагуудын сарын төсвийн хуваарийг баталгаажуулсан байна.

Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын 4.3-т “Аймаг, нийслэлийн төрийн сан нь Засаг даргын баталсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжилтийн эрхийн тооцоог хийж, орон нутгийн төсвийн байгууллагын санхүүжилтийг сар бүрийн ажлын эхний 5 өдөрт багтаан ЗЭБ№1 маягтаар, тусгай зориулалтын шилжүүлгийг санхүүжилт орсноос хойш ажлын 2 өдөрт багтаан ЗЭБ№1 маягтаар тус тус баталгаажуулан аймаг, нийслэлийн төсвийн ерөнхий нягтлан бодогч олгоно” гэснийг мөрдөж ажилласан эсэхийг шалгахад зарим саруудад ЗЭБ№1 маягтыг дутуу хөтөлсөн байна.

Журмын 4.4.-т “Сум, дүүргийн төрийн сан нь Засаг даргын баталсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу сум, дүүргийн төсвийн байгууллагын санхүүжилтийн эрхийн тооцоог хийж санхүүжилтийг сар бүрийн ажлын эхний 5 өдөрт багтаан ЗЭБ№1 маягтаар, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт орсноос хойш ажлын 1 өдөрт багтаан ЗЭБ№1 маягтаар тус тус баталгаажуулан дүүргийн төрийн сангийн мэргэжилтэн, сумын төрийн сангийн төлөөлөгч нар олгоно” - гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Журмын 4.6-д “Орон нутгийн төрийн сан улсын төсвийн байгууллагад олгосон санхүүжилтийн эрхийн тооцоог улирал тутам ЗЭБ№4 маягтаар гаргаж, дараа улирлын эхний сарын 10-ны өдрийн дотор Төв төрийн санд хүргүүлнэ”- гэсний дагуу ЗЭБ№4 маягтыг улирал бүр илгээгээгүй байна.

Төсвийн байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн эрхийг нээхдээ журмын 7.2-т заасны дагуу HT№1 маягтын дагуу бэлтгэж 7.2.1-7.2.4-т заасан материалуудыг хавсаргаж албан бичгээр хүлээн авах ёстой.

HT№1 маягтын дагуу албан бичгээр нэмэлт төсвийг зарцуулах хүсэлтийг хүлээн авсан боловч зарим хавсаргаж ирүүлэх материалуудыг дутуу бүрдүүлж авсан байна. Тухайлбал:7.2.3-т заасан нэмэлт төсвийг зарцуулах төсвийн захирагчийн баталсан төсөв, сарын хуваарийг огт аваагүй байна.

Журмын 7.4-т заасны дагуу “Төсвийн тухай хуулийн 47.2-т заасны дагуу төсвийн байгууллага нь нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланг HT№2 маягтаар гарган төсвийн сарын гүйцэтгэлийн хамт төсвийн тухай хуулийн 8.8.1-т заасан хугацаанд дээд шатны төсвийн захирагчид хүргүүлнэ”, 7.5-д “Орон нутгийн төрийн сан нь нэмэлт төсвийн зарцуулалтын гүйцэтгэлийг эх үүсвэр тус бүрээр улирал тутам HT№3 маягтын дагуу гарган төв төрийн санд хүргүүлнэ”-гэснийг шалгахад хэрэгжүүлж ажилласан эсэх нь тодорхойгүй, холбогдох ажлын баримт байхгүй байна.

Аймгийн ЗДТГ, Өлгий сумын ИТХ, Өлгий сумын ЗДТГ, Орон нутгийн өмчийн газар, Өлгий сумын 3 дугаар бүрэн дунд сургууль, “Эрдэм” цэцэрлэг зэрэг байгууллагыг түүвэрлэн шалгахад төсвийн сар, улирлын хуваарийг дээд шатны төсвийн захирагчаар баталгаажуулсан байна.

Төсвийн хуваарийн дагуу зарцуулалтын эрхийг нээлгэсэн эсэхийг төсвийн хэлбэлзлийн тайлантай тулгаж шалгахад зөрүүтэй байгаа тохиолдол байна.Энэ нь орон нутгийн байгууллагуудад орон нутгийн орлого бүрдүүлэлтийн байдлаас шалтгаалж зарим саруудад санхүүжилтийг дутуу олгодог, зарим зардлуудыг тухайн байгууллагын хүсэлтээр хуваарьт нь өөрчлөлт оруулж санхүүжүүлдэгтэй холбоотой байна.Зардлыг дарааллын дагуу санхүүжүүлсэн бөгөөд 2017 онд төсвийн гүйцэтгэлээс эдийн засгийн ангиллаар бүлгийн дүнгээр хэтэрсэн зардал байхгүй байна.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг төсвийн байгууллагын үндсэн дансанд олгосон байна. Тухайлбал: Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Биеийн тамир спортын газар, Орон нутгийн өмчийн газар, Номын сан, Театр, Музей, сумуудын Соёлын төвүүдэд үндсэн үйл ажиллагааны хүрээнд нэмэлт орлого орсныг тухайн байгууллагуудын үндсэн дансанд олгосон байна.

Тухайн байгууллагууд батлагдсан төсвөөс илүү оруулсан нэмэлт орлогыг төвлөрүүлсэн эсэхийг дээрх байгууллагуудаас түүвэрлэн шалгахад: -Хөгжимт драмын театрын үндсэн үйл ажиллагааны орлогоос хэмнэсэн 4320,0 мянган төгрөгийг оны эцэст касст үлдэгдлээр байлгаад, он гараад үндсэн дансандаа тушаасан, БОАЖГазар зөвшөөрөгдсөн үндсэн үйл ажиллагааны орлогоос илүү орсон орлогыг төвлөрүүлсэн, Орон нутгийн өмчийн газар 2017 онд батлагдсан төсвөөс илүү орлого оруулаагүй байна.

Байгууллагууд нэмэлт орлогыг тушаалд заасан хэмжээний дагуу зарцуулсан байна. Байгууллагууд зөвшөөрөгдсөн үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоос тухайн жилд зарцуулаагүй төвлөрүүлсэн орлого байхгүй байна.

Нэмэлт санхүүжилтээс зарцуулагдаагүй орлогыг оны эцэст нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлсэн хөрөнгө дансанд төвлөрүүлсэн байна. Аймаг болон сумын төрийн сан тус бүр нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн данстай байна.

Б.2. ЗГСУМС систем нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж чадаагүй байна.

Б.2.1. Системийг хэрэглэхэд ойлгомжтой боловч, шаардлагатай үйл ажиллагааны хамрах хүрээг бүрэн хамарч чадаагүй байна.

Сангийн сайдын 2014 оны 95 тоот тушаалаар баталсан “Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам”-аар энэ системд нэвтрэх эрх бүхий хэрэглэгчдийн ажил үүргийн хуваарь, тэдгээрийн систем дээр хийгдэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Сумуудын төрийн сангийн ЗГСУМС-ийн хэрэглэгчдийн нэгдсэн бүртгэлийг аймгийн төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн хөтөлж ажилласан байна.

Журмын 2.4-д “Системд нэвтрэх эрх бүхий хэрэглэгчдийн ээлжийн амралт, гадаад болон дотоод томилолт, хүүхэд асрах чөлөөтэй, түр хугацааны чөлөөтэй байх хугацаанд системийн нэр, нууц үгээ шилжүүлэх тохиолдолд харьяалах нэгжийн удирдах албан тушаалтны холбогдох шийдвэрийг үндэслэн эрхийг шинэ хэрэглэгчид шилжүүлж, тухай бүр аймгийн СТСХ-т албан бичгээр мэдэгдэж байх ёстой.

Баяннуур, Ногооннуур, Бугат, Сагсай, Толбо, Улаанхус, Буянт сумын төрийн сангийн мэргэжилтнүүд амралттай үедээ өөрсдөө ирж гүйлгээгээ хийж, баталгаажуулж байсан тул эрх түр шилжүүлээгүй байна.

Аймгийн төрийн сан, Алтай сум, Өлгий сумын төрийн сангийн мэргэжилтнүүд амралттай, чөлөөтэй байх хугацаандаа зохих журмын дагуу эрх түр шилжүүлж ажилласан байна.

Цэнгэл сумын төрийн сангийн мэргэжилтэн ээлжийн амралттай, түр чөлөөтэй үед ЗГСУМС-д нэвтрэх нэр, нууц үгийг түр хугацаагаар эрх түр шилжүүлж ажиллаагүй ба санхүүгийн албаны дарга гүйлгээг өөрөө шивж, баталгаажуулж ирсэн байна.

2017 онд аймгийн ТЕЗ-ийн ерөнхий нягтлан бодогч, төрийн сангийн дотоод аудит хариуцсан мэргэжилтэн, төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн, Бугат сумын Санхүүгийн албаны дарга, Сагсай сумын Санхүүгийн албаны дарга нар ажлаас чөлөөлөгдөхөд журмын 2.6-д заасны дагуу эрхийг хязгаарлаж, шинэ хэрэглэгчийг бүртгүүлэх тухай хүсэлтийг Төв төрийн санд хүргүүлж ажилласан байна.

Сангийн яамны 2017 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 12-1/1059 тоотоор аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогч нь Сангийн сайдын 2012 оны 294

дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам”-ын шаардлага хангахгүй байгаа учраас системд нэвтрэх зөвшөөрөл өгөхөөс татгалзсан хариу ирүүлсэн тул хүсэлт тавьж ЗГСУМС-д нэвтрэх эрхийг бүртгэлийн мэргэжилтэний нэр дээр авч ерөнхий нягтлан бодогчид шилжүүлэн ашиглуулж ирсэн байна.

2017 оны 8 дугаар сард Сангийн яамны Төрийн сангийн газраас тус аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийсэн шалгалтаар бүртгэлийн мэргэжилтэний нэр дээр зөвшөөрөл Сангийн яамны зөвшөөрөлгүй өөр хүнд шилжүүлж ашиглуулж байгаа нь Сангийн сайдын 2014 оны 95 тоот тушаалаар баталсан “Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам”-ын 5.9 дэх хэсгийг зөрчиж байна гэж тогтоож төсвийн ерөнхий нягтлан бодогчид шаардлага хангасан хүнийг авч томилон системд нэвтрэх эрхийг зохих журмын дагуу авахыг Засаг даргад зөвлөсөн байна..

ЗГСУМС-ийн хэрэглэгчдээс авах Б.2-1-1 судалгаа, санал асуулгад аймгийн ЗГСУМС-ийн нийт 33 хэрэглэгчийг бүрэн хамруулсан.

Б.2-1-1

Асуулт	Санал асуулгад оролцсон хэрэглэгчийн тоо	Тийм	Хувь	Зарим талаар	Хувь	Үгүй	Хувь
Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системийг хэрэглэхэд ойлгомжтой байдаг уу?	33	25	75.8			8	24.2
ЗГСУМС нь таны ажил үүргийг гүйцэтгэх шаардлагыг хангаж, үйл ажиллагааны хамрах хүрээг бүрэн хамарч чаддаг уу?	33	23	69.7	10	30.3		
ЗГСУМС -д өгөгдөл оруулах, боловсруулах, тайлан мэдээ гаргах явцад саатал бэрхшээл тохиолддог уу?	33	7	21.2	20	60.6	6	18.2
Таны хэрэглэж буй компьютер техник, тоног төхөөрөмжийн хүчин чадал бүрэн хангагдсан уу?	33	8	24.2	11	33.3	14	42.4

Санал асуулгын нэгтгэсэн дүнгээс харахад:

- Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системийг хэрэглэхэд ойлгомжтой байдаг уу?-гэсэн асуултад нийт хэрэглэгчийн 75,8 хувь нь тийм, 24,2 хувь нь үгүй гэж хариулсан байна.
- ЗГСУМС нь таны ажил үүргийг гүйцэтгэх шаардлагыг хангаж, үйл ажиллагааны хамрах хүрээг бүрэн хамарч чаддаг уу? –гэсэн асуултад хэрэглэгчдийн 69,7 хувь нь тийм, 30,3 хувь нь заримдаа гэж хариулсан байна.
- ЗГСУМС -д өгөгдөл оруулах, боловсруулах, тайлан мэдээ гаргах явцад саатал бэрхшээл тохиолддог уу?-гэсэн асуултад 21.2 хувь тийм, 60,6 хувь нь заримдаа, 18,2 хувь нь үгүй гэсэн байна.
- Таны хэрэглэж буй компьютер техник, тоног төхөөрөмжийн хүчин чадал бүрэн хангагдсан уу?-гэсэн асуултад 24,2 хувь нь тийм, 33,3 хувь нь заримдаа, 42,4 хувь нь үгүй гэжээ.

Дээрх санал асуулгыг дүгнэхэд: ЗГСУМСистем нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж чадаагүй, системд өгөгдөл оруулах, боловсруулах, тайлан мэдээ гаргах явцад саатал, бэрхшээл байнга тохиолддог, төрийн сангуудад ашиглагдаж байгаа техник, тоног тоног төхөөрөмжийн хүчин чадал муу байгаа дүнтэй байна.

Тулгарч буй хүндрэл бэрхшээлийн талаар:

Асуулт	Тулгарч буй асуудал, хүндрэл бэрхшээл
<i>Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системийг хэрэглэхэд ойлгомжтой байдаг уу?</i>	1. Олон дамжлагатай. /Аймгийн төрийн сан/ 2. Системд нэвтрээд орсоны дараа гүйлгээ баталгаажуулах явцад төсвийн хэлбэлзэл харах болоход сүлжээнээс гарч дахин ордог нь бэрхшээлтэй байна. Зэрэг орох болгох хэрэгтэй байна. /Өлгий сум/ 3. ЗГСУМС-ийн төрийн сангийн сүлжээний гүйлгээ хийх төхөөрөмжийг хадгалж хамгаалах эзэн нь байхгүй. Холбооны газар хариуцдаггүйгээс төхөөрөмж эвдэрч, шатах тохиолдол гарч байгаа нь хүндрэлтэй байна. /Баяннуур сум/ 4. 2018 оноос хэрэглэж байгаа мэдээллийн систем нь маш ойлгомжгүй. /Цэнгэл сум/ 5. Өдөр тутам гүйлгээ хийдэг Preebalans программын хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. /Цагааннуур тосгон/ 6. Зарим үед тог тасардаг. /Дэлүүн сум/
<i>ЗГСУМС нь таны ажил үүргийг гүйцэтгэх шаардлагыг хангаж, үйл ажиллагааны хамрах хүрээ бүрэн хамарч чаддаг уу?</i>	1. Ажил үүрэг гүйцэтгэхэд шаардлага хангаж байгаа боловч тайлан мэдээ авахад бид дутуу ойлголттой байна. /Цэнгэл сум/
<i>ЗГСУМС -д өгөгдөл оруулах, боловсруулах, тайлан мэдээ гаргах явцад саатал бэрхшээл тохиолддог уу?</i>	1. Зарим үед сүлжээ тасалддаг. /Аймгийн төрийн сан, Буянт / 2. Гурван сум шилэн кабельд холбогдсон, бусад сумууд антэнд холбогдсон нь гүйлгээ хийхэд бэрхшээлтэй байна. /Аймгийн төрийн сан/ 3. Дансны хуулга авах, мэдээ тайлан гаргахад хүндрэлтэй байна. Сангийн яамны 71001111 утас авдаггүй. /Өлгий сум, Цэнгэл сум/ 4. Төрийн сангийн сүлжээ маш удаан ажиллагаатай учраас хуулга гаргахад нийлээн удаан, гацаж байна. /Сагсай, Ногооннуур сум / 5. Өгөгдөл оруулах эрхийг сумд өгөх /Алтай сум/
<i>Таны хэрэглэж буй компьютер техник, тоног төхөөрөмжийн хүчин чадал бүрэн хангагдсан уу?</i>	1. Өлгий сумд 50 байгууллага нэгтгэдэг. Компьютерээр гүйлгээ баталгаажуулдаг ба интернетэд холбох гэж дахин дахин салгадаг. СЯ-ны сүлжээнд холбогдоход хүндрэлтэй байдаг. Ноутбүүк шаардлагатай байна. Сангийн яамны сүлжээ хариуцсан хүн аймгаар явж ажиллахгүй байна. /Өлгий сум/ 2. Төрийн сангийн гүйлгээ хийх компьютер элэгдэж хуучирсан, хугацаа нь дууссан, дуу шуугиантай. /Аймгийн төрийн сан, Алтай сум, Баяннуур сум/ 3. Хүчин чадал муу, маш удаан, 2006 онд ирсэн. /Цэнгэл сум, Толбо сум, Ногооннуур сум, Буянт сум, Алтай сум/ 4. Тоног төхөөрөмжөөр хангагдаагүй. /Цэнгэл сум/ 5. Санхүүгийн албаны дарга зөөврийн компьютер хэрэглэдэг тул заримдаа сүлжээ орохгүй байна. Учир нь байнга авч явдаг тул хөдөлгөөн орж гэмтдэг асуудал байна. /Сагсай/

Санал асуулгын хуудсаар системийн хэрэглэгчдээс дараах санал, хүсэлтүүдийг ирүүлсэн байна.

1. Зарим үед сүлжээ гацах, сүлжээ тасрах явдал гардаг. Ялангуяа оны эцэст ажил хийхэд их бэрхшээл учирдаг тул сүлжээг сайжруулах, техник хэрэгслийг шинэчлэх шаардлагатай гэсэн санал хүсэлт ирүүлсэн байна.
2. ЗГСУМС-ийн аюулгүй байдалд учруулдаг болон болзошгүй эрсдэл, тохиолдлын талаар:
 - Хөдөө орон нутагт цахилгаан хангамж муу, зарим санхүүжилтийн эрхийг орон нутаг өөрсдөө нээдэг байх,
 - Тог баригчгүй байгаа тул цахилгааны хэлбэлзлээс сүлжээний тоног төхөөрөмж шатаж магадгүй байна.

Сумуудад ажиллах явцад ажиглагдсан зүйл төрийн сангийн техник тоног төхөөрөмж элэгдэж хуучирсан, зарим сумдад тухайлбал Цэнгэл сумын

төрийн сан 2006 оны хуучин компьютер ашиглаж байсан. Бугат сумын санхүүгийн албаны даргад гүйлгээ баталгаажуулах компьютер байхгүй, төрийн сангийн төлөөлөгч дундаа нэг компьютертэй байсан.

Б.2.2. Системийн программ хангамж, мэдээллийн технологи аюулгүй ажил хангагдсан байна.

ЗГСУМС-д нэвтрэх эрх авсан аймгийн төрийн сан болон сумын төрийн сангийн ажилтнууд Сангийн сайдын 2014 оны 95 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам”-ын гуравдугаар бүлэгт заасан ажил үүргийн хуваариар системд нэвтэрч ажил гүйцэтгэсэн байна.

ЗГСУМС-ийн хэрэглэгчдээс ҮАГ-аас боловсруулж ирүүлсэн Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системийн талаарх шалгах хуудсаар авсан санал асуулгын дүнг нэгтгэхэд:

Б.2-1-2

Асуулт	Санал асуулгад оролцсон хэрэглэгчийн тоо	Тийм	Хувь	Зарим талаар	Хувь	Үгүй	Хувь
Системийн функционал администратор журамд заасан хугацаанд тайлант үеийг өндөрлүүлж, эхлүүлж байна уу?	33	27	81.8	6	18.2		
Танд зохих эрхийг бүрэн олгосон уу?	33	23	69.7	8	24.2	2	6.1
Системд нэвтрэх нэр, нууц үгийг журмын дагуу олгосон уу?	33	33	100.0				
Таны эрхийг хязгаарласан тохиолдол бий юу?	33	3	9.1	5	15.2	25	75.8
Системийн функционал администратор систем дэх хэрэглэгчдийн эрхийн хязгаарлалтыг журмын дагуу гүйцэтгэж байна уу?	33	31	93.9	2	6.1		
Таны эрхийг давхардуулан ашигладаг хэрэглэгч байгаа юу?	33	2	6.1			31	93.9

- Системийн функционал администратор журамд заасан хугацаанд тайлант үеийг өндөрлүүлж, эхлүүлж байгаа эсэхэд хэрэглэгчдийн 81,8 хувь нь тийм гэж хариулжээ.
- Танд зохих эрхийг бүрэн олгосон уу?-гэсэн асуултад 69,7 хувь нь тийм ,
- Системд нэвтрэх нэр, нууц үгийг журмын дагуу олгосон уу?-гэсэн асуултад хэрэглэгчид 100 хувь тийм,
- Таны эрхийг хязгаарласан тохиолдол бий юу?-гэсэн асуултад хэрэглэгчдийн 9,1 хувь нь тийм, 15,2 хувь нь зарим талаар, 75,8 хувь нь үгүй гэж хариулсан байна.
- Системийн функционал администратор систем дэх хэрэглэгчдийн эрхийн хязгаарлалтыг журмын дагуу гүйцэтгэж байна уу? –гэсэн асуултад нийт хэрэглэгчийн 31 буюу 93,9 хувь нь тийм, 2 буюу 6,1 хувь нь заримдаа гэж хариулжээ.
- Таны эрхийг давхардуулан ашигладаг хэрэглэгч байгаа юу?-гэсэн асуултад 2 хэрэглэгч тийм, 31 хэрэглэгч үгүй гэж хариулсан байна.

Тийм гэж хариулсан хэрэглэгчдийг тодруулахад аймгийн төсвийн мэргэжилтэн, боловсрол хариуцсан төсвийн мэргэжилтэн нар нэг эрхийг давхардуулан ашигладаг байна.

Б.3. Төрийн сангийн дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Б.3.1. Төлбөр тооцооны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлсэн боловч биелэлтийг хангуулж ажиллаагүй байна.

Аймгийн Засаг даргын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлэх талаар тусгаж, Засаг даргын 2017 оны 1 дүгээр сарын 05-ны өдрийн А/05 дугаар захирамжаар сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх төлөвлөгөөг баталсан байна.

СТСХ-ээс төлөвлөгөөний дагуу 14 сумын төрийн сангийн үйл ажиллагаанд МУЗГ-ын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”, Сангийн сайдын 2014 оны 65 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ын дагуу эрсдэлд суурилсан дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллажээ.

Дотоод хяналтаар төрийн сангийн хэрэгжүүлж буй 9 төрлийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, заавар журмын дагуу хийж гүйцэтгэж байгаа эсэхийг санхүүгийн баримтад үндэслэн шалгаж, дүгнэлт гаргасан байна.

Шалгалтаар дараах зөрчил дутагдал илэрчээ.Үүнд:

-Алтай, Алтанцөгц, Дэлүүн, Цагааннуур сумдад бүрдэл болоогүй гарын үсгээр төсвийн байгууллагын гүйлгээг хийсэн, Улаанхус, Ногооннуур, Баяннуур, Цэнгэл сумдад шаардлага хангаагүй анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн, Дэлүүн сумд удирдлагын шийдвэргүйгээр ЗГСУМС-д нэвтрэх эрхээ бусдад шилжүүлсэн.

-Ногооннуур, Улаанхус, Баяннуур, Өлгий сумдад ЗГСУМС-д алдаатай шивсэн гүйлгээг залруулахдаа мемориалын баримт үйлдэж архивын баримтад хавсаргаагүй, Бугат, Сагсай сумдад төлбөрийн хүсэлтэд гүйлгээ хийсэн төрийн сангийн тэмдэг дарж гарын үсэг зуралгүй гүйлгээг хийж баталгаажуулсан.

-Ногооннуур, Бугат, Цэнгэл, Баяннуур, Өлгий сумдад орлого бууруулж гүйлгээ хийхдээ орлогын хуулга хавсаргаагүй, Баяннуур, Бугат, Сагсай сумдад засвартай төлбөрийн хүсэлтээр гүйлгээ хийсэн, Ногооннуур, Бугат сумдад гарын үсгийн баталгааг архивын нэгж үүсгэж аваагүй, Булган, Цэнгэл, Буянт, Бугат сумдад батлагдсан төлбөрийн хүсэлтээр гүйлгээг хийгээгүй байна.

Шалгалтын дүнгээр дээд байгууллагаас боловсруулан гаргасан журмуудын талаарх ном, товхимол, гарын авлага төрийн сангийн бүх нэгж, мэргэжилтэн нарт жигд хүргэгдсэн боловч төрийн сангийн ажилтнууд эдгээр хууль, журмыг уншиж судлан өөрийн болгодоггүй, шинэчлэн батлагдсан журмын талаар мэдээллийг харилцагч байгууллагуудад бүрэн гүйцэд хүргэдэггүй зэрэг нь орон нутагт төрийн сангийн хяналтыг сулруулах нөхцөлийг бүрдүүлж байна гэж дүгнэжээ.

Дотоод хяналтаар илэрсэн алдаа дутагдлыг арилгуулах, цаашид алдаа зөрчил гаргахгүй байх талаар төрийн сангийн ажилтнуудад сургалт зохион байгуулж, сайн үнэлгээ авсан албан хаагчийг урамшуулах, ажилдаа хариуцлагагүй хандсан сумын санхүүгийн албанд хариуцлага тооцох шийдвэрийг танилцуулж ажилласан хэмээн тайландаа дурдсан боловч дотоод хяналтын тайланг хэлэлцүүлсэн, хүргүүлсэн, үр дүнг үнэлсэн талаар нотлох баримт материал байхгүй байна.

Сангийн сайдын 2014 оны 65 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ын дагуу эрсдэлийн үнэлгээг 12 сумын төрийн сангийн нэгжид хийсэн байна.

Бугат, Өлгий, Цэнгэл сумдын төрийн сангийн нэгж “өндөр”, Булган, Баяннуур, Ногооннуур, Буянт, Сагсай, сумдын төрийн сангийн нэгж “дунд”, Алтай, Алтанцөгц, Цагааннуур, Дэлүүн сумдын төрийн сангийн нэгж “бага” эрсдэлтэй гэж үнэлэгджээ. Улаанхус, Толбо сумдын төрийн сангийн нэгжид эрсдэлийн үнэлгээ хийгээгүй байна.

Сумын төрийн сангуудад хийсэн дотоод шалгалтын дүнгээр өгсөн зөвлөмж, түүнийг биелэлтийг хангуулсныг нотлох баримт байхгүй байна.

Сангийн яамны Төрийн сангийн газраас 2017 оны 8 дугаар сард тус аймгийн СТСХ-ийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын тайланд тус хэлтсийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн нь аймгийн Төрийн санд хийх дотоод хяналтын төлөвлөгөөг хэлтсийн даргаар батлуулж мөрдөөгүй байна гэж дүгнэсэн байна.

Үүнээс дүгнэж үзэхэд 2017 онд тус аймгийн төрийн сангийн дотоод хяналт хангалтгүй хэрэгжсэн байна.

Б.3.2. Төсвийн хэрэгжилт мөнгөн хөрөнгийн удирдлагад тавих дотоод хяналт хангалтгүй байна.

Аймгийн СТСХ-ээс сумдын төрийн сангийн нэгжүүдэд хийсэн дотоод хяналтаар төсвийн хэрэгжилт, мөнгөн хөрөнгийн удирдлагад тавих дотоод хяналтын чиглэлээр төрийн сангийн хэрэгжүүлж буй 4 төрлийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, заавар журмын дагуу хийж гүйцэтгэж байгаа эсэхийг шалгаж үзэхэд дараах зөрчил илэрсэн байна.

- Бугат, Цэнгэл сумдад “Төсвийн тухай хууль”-ийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийг “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын 7.1, 7.2, 7.3, 7.4, 7.5-т заасны дагуу баримтлан ажиллаагүй,
- Цэнгэл, Баяннуур, Бугат сумдад төсвийн гүйцэтгэлийн тайланг цаглабарын дагуу бүрэн хянаж, үнэн зөв программд нэгтгээгүй.

Дээрх зөрчлийн хүрээнд сумдын төрийн сан Засаг даргын баталсан сар улирлын хуваарийн дагуу санхүүжилтийг батлагдсан маягтын дагуу зөрүүгүй олгож, төсвийн багцын үлдэгдлийг ЗГСУМС-тэй тулган баталгаажуулах ажлыг тогтмол хийж байх шаардлагатайг анхааруулан ажилласан байна.

Төрийн сангийн нэгжийн үйл ажиллагааны дотоод хяналтаар Баяннуур, Бугат, Булган, Ногооннуур, Сагсай, Улаанхус Цэнгэл сумдын төрийн сангийн нэгжийн төсөвт байгууллагуудын зарлагын гүйлгээнд тавих хяналт сул, бусад төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаа хэвийн байна гэж дүгнэжээ.

Сангийн яамны Төрийн сангийн газраас СТСХ-ийн 2017 оны 1-6 дугаар сарын төсвийн төлөвлөлт, санхүүжилт бүртгэл хөтлөлт, төлбөр тооцоо, тайлагналт, архив хөтлөлт, дотоод үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар 14 төрлийн зөрчил илрүүлж, тус хэлтсийн үйл ажиллагааг “өндөр” эрсдэлтэй гэж дүгнэж, илэрсэн алдаа зөрчлийг засаж, залруулах, цаашид давтан гаргахгүй байх талаар 24 заалттай зөвлөмж өгсөн байна.

СТСХэлтэс дотоод хяналтын мөрөөр өгсөн зөвлөмжийн дагуу ажлын төлөвлөгөө батлуулж 22 зөвлөмжийн биелэлтийг хангуулсан материал ирүүлснийг аудитаар давтан шалгаж үзэхэд зарим зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллаагүй байна.

Тухайлбал: Төрийн сангийн өдрийн мемориал, гарын үсгийн баталгаа, ЗГСУМС дэх хэрэглэгчдийн хөдөлгөөний тайлан, төрийн сангийн тамга тэмдийн бүртгэл, төсвийн байгууллагын нэмэлт санхүүжилтийн эрх нээсэн баримт, төсвийн гүйцэтгэл, санхүүжилтийн баримтуудыг журмын дагуу бүрэн гүйцэд архивлах, эмх цэгцтэй архив хөтлөлтийн дэвтэр гарган хэлтсийн нэг мэргэжилтэнд хариуцуулах гэсэн зөвлөмжүүд хэрэгжээгүй байна.

СТСХ-ийн дотоод хяналтаас сумдын төрийн сангийн нэгжид хийсэн хяналт шалгалтын дүнгээр илэрсэн алдаа зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж хүргүүлсэн эсэх, хэрэгжилтийг давтан шалгаж хангуулсан эсэхийг нотлох баримт материал байхгүй байна.

Дээрх байдлаас дүгнэж үзэхэд аймгийн Төрийн сангийн дотоод хяналт хийх төлөвлөгөөг батлуулан, хэрэгжүүлдэг боловч, хяналтын үр дүнгээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, давтан гаргуулахгүй байх талаар хангалтгүй ажилласан нь дотоод хяналтын үр нөлөөг бууруулсан байна.

Аудитын дүнгээр аймгийн СТСХ-ийн даргад албан шаардлага, 3 заалт бүхий зөвлөмж, Баяннуур, Бугат, Буянт, Ногооннуур, Улаанхус, Цэнгэл, Толбо, Өлгий, Дэлүүн сумуудын ЗДТГазар, Цагааннуур тосгоны Захирагчийн албад албан шаардлага хүргүүлэв.

Албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн аймгийн СТСХ-ийн дарга, дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн, төсвийн мэргэжилтэн, Өлгий, Баяннуур сумын Санхүүгийн албаны дарга, Баяннуур сумын төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн нарт хариуцлага тооцуулах саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1-р бүлэг. Төрийн сангийн эрхзүйн орчин, тогтолцоог оновчтой зохион байгуулах шаардлага байна.

1.1 Төрийн сангийн эрхзүйн орчин, тогтолцоог оновчтой зохион байгуулах шаардлага байна.

1.2. Төрийн сангийн тогтолцоог чиг үүрэгтэй уялдуулж шинэчлэн сайжруулах шаардлага байна.

1.3. Хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх зохистой бүтцийг бий болгоогүй байна.

1.4. Төрийн сангийн үйл ажиллагааг үр нөлөөтэй явуулах бодлого, стратеги байхгүй байна.

2-р бүлэг. Төрийн сангийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулах шаардлага байна.

2.1. Төрийн сангийн төлбөр тооцоо, төсөв, мөнгөн хөрөнгийн удирдлага, зохицуулалтыг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж ирсэн байна.

2.2. ЗГСУМСистем нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж чадаагүй байна.

2.3. Төрийн сангийн дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлж ажиллаагүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Х.Ерболд

1. Сумын Санхүүгийн алба, төрийн сангуудыг мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангаж, ЗГСУМС-ийн системийн хэрэглэгчдийн үйл ажиллагаанд гарч байгаа зарим хүндрэл бэрхшээлүүдийг холбогдох газарт асуудал тавьж шийдвэрлүүлэх, сумын төрийн сангуудын техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах, ажиллах нөхцөл бололцоогоор хангах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах;
2. Сумын санхүүгийн албаны дарга, төрийн сангийн мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтыг Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”, Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолт боловсруулах заавар”-ын дагуу нэг заавар стандартаар хариуцаж ажиллах чиг үүргийг бүрэн тусгаж шинэчлэн боловсруулж, батлуулж ажиллах;
3. Нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн дансны нийт 24,3 сая төгрөгийн үлдэгдлийг 2018 оны 12 дугаар сарын 25-ны дотор орон нутгийн ерөнхий орлогын дансанд хааж, үлдэгдэлгүй болгох;

Зөвлөмжийн биелэлтийг 2019 оны 04 дүгээр сарын 01-ний дотор ирүүлэх;

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагын санал

(Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс ирүүлсэн санал)

		АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР 83129 Өлгий, Баян-Өлгий аймаг, Утас/Факс: (976) 7042-3762		
2018.11.02 № 5-03/718 танай -ны № -т		
Санал хүргүүлэх тухай		
Аймгийн Төрийн аудитын газраас аймгийн Санхүү, төрийн сангийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын талаар дараах санал, тайлбарыг хүргүүлж байна. Аймгийн Төрийн аудитын газраас Төрийн сангийн чиг үүргийг холбогдох хуульд оновчтой тодорхойлсон гэж үзэх үндэслэлгүй байна гэж дүгнэсэн байна. Төсвийн тухай хуулийн 36, 37 дугаар зүйлд заасны дагуу Төрийн сангийн тогтолцоо, хэрэгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Сангийн сайдын 90 тоот тушаалаар баталсан "Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар" -т тусгасан нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж, ямар нэгэн хууль, тушаалыг зөрчөөгүй тул оновчтой зохион байгуулагдаагүй гэх үндэслэл байхгүй байна. Өөрөөр хэлбэл Төсвийн тухай хууль, Сангийн сайдын тушаалд Төрийн сангийн тогтолцоо, чиг үүргийг дутуу юм уу оновчтой тусгаж өгөөгүй гэсэн зүйл бичсэн байна. -Хуульд зааснаас өөрөөр зохицуулалт хийх боломжгүй гэдгийг анхаарна уу. Төрийн сангийн тогтолцоо бодлого, чиг үүрэгтэйгээ нийцээгүй байна гэсэн дүгнэлт өгсөн байна. Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн "Сумдад санхүүгийн алба байгуулах тухай" 326 дугаар тогтоол болон Засгийн газраас баталсан журмыг баримтлан ажилласан учир Төрийн сангийн тогтолцоо, бодлого, чиг үүрэгтэйгээ нийцээгүй гэх нь үндэслэлгүй. Төрийн сангийн чиг үүргийг шинэчлэн сайжруулах бодит хэрэгцээ шаардлага байна гэж дүгнэсэн байдалд тайлбар өгөхөд: Хэрвээ Төрийн сангийн чиг үүргийг шинэчлэн сайжруулах бодит хэрэгцээ, шаардлага байгаа бол Төсвийн хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэж байна.		

00000125

2.

Төрийн сангийн үйл ажиллагааг үр нөлөөтэй явуулах бодлого, стратеги байхгүй байна гэж дүгнэсэн байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг 2013-2016 он хүртэл боловсруулан баталсан ба дараагийн жилүүдийн төлөвлөгөө батлагдаагүй учир Санхүү, төрийн сангийн стратеги төлөвлөгөөг төлөвлөж чадаагүй болно.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



ХЕРБОЛ

Саналд өгөх тайлбар:

Аудитын тайланд 1 дүгээр бүлгийн дүгнэлтийг “Төрийн сангийн эрхзүйн орчин, тогтолцоог оновчтой зохион байгуулах шаардлага байна” гэж өөрчлөлт оруулав. Төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой бусад дүгнэлтүүдэд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

ТАЙЛАНГ ХЯНАЖ, БАТАЛГААЖУУЛСАН:

Дарга бөгөөд тэргүүлэх аудитор

М.Хуанган

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

Аудитын менежер

Х.Женисбек

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН :

Ахлах аудитор

Д.Назгүл

Аудитор

Р.Баярмаа